

XXX-ийг зөв өмсөж байж л үр дүнг нь үзнэ 2025 оны 11-р сар



1-р зураг. Даралт хэмжигчийг тусгаарлах хаалт



2-р зураг. Бөглөрсөн даралт хэмжигч ослын дараа харагдах байдал

2023 оны 5 сарын 4-ний өдөр Калифорни муж дах цэвэршүүлэх үйлдвэрт хүхэрт устөрөгчийн хий (H_2S) агуулсан 790 фунт (358 кг) орчим хэмжээтэй нүүрс-устөрөгчийн холимог алдагдсан. Хүхэрт устөрөгчийн хорт хийнд нэг ажилтан өртөж гэмтсэн.

Эвдэрсэн даралт хэмжигчийг солих ажилд 4 ажилтан томилогдсон. Доод хаалт (дугуй цэнхрээр тэмдэглэсэн) эвдэрсэн нь ойлгомжтой байсан тул засварчид даралт хэмжигчтэй ойр хаалтыг (дөрвөлжин цэнхрээр тэмдэглэсэн) хаасан. Хаалт дотор талдаа гацсанаас болж гүйцэд хаагдаагүйг мэдээгүй. Нэг ажилтан даралт хэмжигчийг салгаж эхэлсэн. Эрээсийг суллаж байх үед даралт хэмжигч дотор үлдэгдэл даралт байгаа шинж тэмдэг мэдэгдээгүй. Даралт хэмжигчийг тайлж авсны дараа процессын шингэний даралтаар шугам хоолой дотор байсан бохирдол суллагдаж, хүхэрт устөрөгчийн хорт хий агуулсан нүүрс-устөрөгчийн шатамхай холимог гадагш алдагдсан. Ажилтнуудын аль нь ч амьсгал хамгаалах баг зүүгээгүй, хүхэрт устөрөгчийн хорт хийнээс хамгаалагдаагүй байсан. 3 ажилтан ухаан ороод зугтаж гарсан. 1 ажилтан ухаан ороогүй ба онцгой байдлын ажилтнууд түүнийг аварч эмнэлэгт хүргэж, эмчилгээнд хамруулсан.

Ослын судалгаагаар даралт хэмжигчийг салгахын өмнө тусгаарлалтыг үр дүнтэй гүйцэтгээгүй байсан нь тогтоогдсон. Даралт хэмжигч бөглөрсөн байсан нь даралт худлаа заах шалтгаан болсон. Ажилтнууд зохих XXX өмсөөгүй байсан нь ослын үр дагаврыг ихэсгэсэн.

Та мэдэх үү?

- XXX бол аюулгүй ажиллагааг хангах захиргааны арга хэмжээ бөгөөд ажилтнууд тухайн ажилд ямар XXX тохирохыг мэддэг, зөв өмсөж чаддаг байх ёстой. XXX нь бие болон амьсгалыг өртөлтөөс хамгаалдаг.
- Үйл ажиллагааны болон засвар үйлчилгээний журамд тухайн ажлыг аюулгүй гүйцэтгэхийн тулд ямар XXX өмссөн байх шаардлагатайг зааж өгдөг.
- Хор аюулын лавлахад өмсөхийг санал болгох XXX-ийг заасан бүлэг байдаг.
- XXX үр дүнгүй байх хэд хэдэн тохиолдол бий:
 - XXX ашиглаагүй, эсвэл буруу ашигласан.
 - XXX-ийг зөв ашиглаж сураагүй.
 - Заасан XXX нь тухайн ажлыг гүйцэтгэхэд тохирохгүй.
 - Ажлын явцад ажлын даалгавар өөрчлөгдсөн.
 - XXX муудаж, чанараа алдсан.
- XXX аюултай материал алдагдахаас хамгаалж чадахгүй боловч нэгэнт алдагдсан тохиолдолд хамгаалалт болно.

Та юу хийх ёстой вэ?

- Ажил эхлэхийн өмнө ажлын журамтай танилцаж, ямар XXX ашиглахыг мэдэж авах ёстой. Хор аюулын лавлахаас бас ямар XXX ашиглахыг мэдэж авч болно.
- XXX-ээ ашиглахын өмнө шалгаж, хэвийн байгаа эсэхийг нягтална.
- Ажил дуусах, аюулыг тусгаарлах хүртэл зохих XXX-ийг тайлахгүй.
- XXX-ээ тогтмол шалгаж, хэвийн байгаа эсэх, амьсгалын бортого зэрэг чухал эд ангиудын хугацаа дуусаагүй эсэхийг нягтална.

XXX-дээ анхаарвал XXX таныг аварна